



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 110

Номгон

Г Ээлжит хуралдааныг товлон зарлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэхь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит ХҮИИ хуралдааныг 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 10:00 цагт Баянхонгор сумын төвд хуралдуулахаар товлон зарлаж, дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1.1. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөөллийн тухай


1.2. Аймгийн 2020 оны төсвийн төслийн тухай

1.3. “Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжил”-ийн жилийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайлангийн тухай

1.4. Баянхонгор аймгийн боловсрол салбарын стратеги төлөвлөгөөг батлах тухай

2. Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар урьдчилан хэлэлцүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190093